Шүүгдэгч Ё.Бадамжав нь Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Хүүхдийн салбар эмнэлэгт их эмчээр ажиллаж байхдаа өвчтөнд, Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад хамаарах үүргээ биелүүлээгүй ба Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн Эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг хэсгийн 28.4.3 дахь дахь хэсэгт эмнэлгийн мэргэжилтэн, үйл ажиллагаандаа эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажиллах гэж заасан, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн эмнэл зүйн заавар батлах тухай” А/489 тоот тушаалын нэгдүгээр хавсралт, Хүүхдийн өвчний цогц менежмент, Эрүүл мэндийн технологи.Хүүхдэд зонхилон тохиолдох өвчний оношилгоо эмчилгээний MNS 5836:2008 стандартын 20 дугаар хэсэг Хүүхдийн уушгины цочмог үрэвсэл өвчний оношилгоо эмчилгээ, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа 5095:2017 стандартад зааснаар тус стандартын 12 дугаар хэсгийн 12.1.5 дахь хэсэг “Үзлэг оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх бүрд холбогдох анхан шатны бүртгэл, маягт, хяналтын хуудсыг бүрэн хөтөлнө”, стандартын 12 дугаар хэсгийн 12.1.8 дахь хэсэг “Эмнэлгийн жижүүр эмч нь үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээг ажлын бус цагаар бүрэн хариуцна”, стандартын 12 дугаар хэсгийн 12.1.9 дэх хэсэг “Үйлчлүүлэгчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээг өвчний түүх, иргэний эрүүл мэндийн дэвтэрт стандартын дагуу тодорхой тэмдэглэж, бүрэн хөтөлнө” гэж заасныг тус тус зөрчиж, уг стандарт, журам, тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй, мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу үйл ажиллагааны алдаа гаргаж, тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлж байсан өвчтөн 3 настай, эмэгтэй, Э.Э эмчлэгч эмчээр ажиллахдаа, 2023 оны 01 дүгээр сарын 07-ны өдрөөс 09-ний өдрийн хооронд түүний биед үзлэг, эмчилгээ огт хийгээгүйгээс уушгины хатгалгаа оношлогдохгүй хүндэрч, үжлийн байдалд орсны улмаас эмчилгээ оройтож, улмаар өвчтөн Э.Э нас барсан,

Шүүгдэгч Х.Бадамсүрэн нь Баянгол дүүргийн Эрүүл мэндийн төвийн харьяа Хүүхдийн салбар эмнэлгийн их эмчээр ажиллаж байхдаа буюу тухайн эмнэлгийн хүлээн авах яаралтай тусламжийн тасагт жижүүр эмчээр ажиллах явцдаа өвчтөнд Эмнэлгийн тусламж үйлчилгээний тухай хуулийн 3 дугаар зүйлийн 3.1.1 дэх заалтад хамаарах үүргээ биелүүлээгүй ба Эрүүл мэндийн тухай хуулийн 28 дугаар зүйлийн Эмнэлгийн мэргэжилтний эрх, үүрэг хэсгийн 28.4.3 дахь хэсэгт эмнэлгийн мэргэжилтэн, үйл ажиллагаандаа эрүүл мэндийн тухай хууль тогтоомж, оношилгоо, эмчилгээ, урьдчилан сэргийлэх ажлын стандарт, технологи, эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх удирдамжийг мөрдөж ажиллах гэж заасан, Эрүүл мэндийн сайдын 2018 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн “Хүүхдэд үзүүлэх яаралтай тусламжийн эмнэл зүйн заавар батлах тухай” А/489 тоот тушаалын нэгдүгээр хавсралт, Хүүхдийн өвчний цогц менежмент, Эрүүл мэндийн технологи.Хүүхдэд зонхилон тохиолдох өвчний оношилгоо эмчилгээний MNS 5836:2008 стандартын 20 дугаар хэсэг Хүүхдийн уушгины цочмог үрэвсэл өвчний оношилгоо эмчилгээ, Нэгдсэн эмнэлгийн бүтэц үйл ажиллагаа 5095:2017 стандартад зааснаар тус стандартын 12 дугаар хэсгийн 12.1.5 дахь хэсэг “Үзлэг оношилгоо, шинжилгээ, эмчилгээ хийх бүрд холбогдох анхан шатны бүртгэл, маягт, хяналтын хуудсыг бүрэн хөтөлнө”, стандартын 12 дугаар хэсгийн 12.1.8 дахь хэсэг “Эмнэлгийн жижүүр эмч

нь үйлчлүүлэгчийн оношилгоо, эмчилгээг ажлын бус цагаар бүрэн хариуцна”, стандартын 12 дугаар хэсгийн 12.1.9 дэх хэсэг “Үйлчлүүлэгчийн үзлэг, оношилгоо, шинжилгээ, эмчилгээг өвчний түүх, иргэний эрүүл мэндийн дэвтэрт стандартын дагуу тодорхой тэмдэглэж, бүрэн хөтөлнө” гэж заасныг тус тус зөрчиж, уг стандарт, журам, тушаалыг үйл ажиллагаандаа мөрдөж ажиллаагүй, мөн эмнэлгийн тусламж, үйлчилгээ үзүүлэх үүргээ зохих ёсоор биелүүлээгүй буюу үйл ажиллагааны алдаа гаргасны улмаас тухайн эмнэлэгт хэвтэн эмчлүүлэхээр 2023 оны 01 дүгээр сарын 07-ны өдөр ирсэн байсан өвчтөн 3 настай, эмэгтэй, Э.Э яаралтай тусламжийн тасагт хүлээн авч, үйлчилгээ үзүүлж ажиллахдаа, өвчтөний биеийн байдалд үзлэг, хяналтыг зохих журмын дагуу хийгээгүй, биеийн байдлыг зөв эрэмбэлж, түүний өвчнийг ялган оношлоогүй, эмчлэгч эмчид зохих ёсоор хүлээлгэж өгөөгүйгээс уушгины хатгалгаа оношлогдохгүй хүндэрч, үхлийн байдалд орсны улмаас эмчилгээ оройтож, улмаар өвчтөн Э.Э нас барсан гэх гэмт хэрэгт холбогджээ.